

АГУУЛГА

1. Товчилсон үгийн жагсаалт	3
2. 2017 оны зорилт	4
3. Гүйцэтгэлийн аудитын талаар	5
4. Нийцлийн аудитын талаар	5
5. Аймгийн ИТХ-ын захиалгат аудит	6
6. Санхүүгийн тайлан баталгаажуулалтын дүнгийн талаар	6
7. Захиргаа хүний нөөц удирдлага нийтлэг үйлчилгээ, зохион байгуулалт	11
8. Санхүүгийн талаар	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

- ❖ **МУ** - Монгол Улс
- ❖ **ҮАГ** – Үндэсний аудитын газар
- ❖ **МУЕА** - Монгол Улсын Ерөнхий аудитор
- ❖ **ИТХ** - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- ❖ **ОНХС** – Орон нутгийн хөгжлийн сан
- ❖ **ТӨХК** – Төрийн өмчит хувьцаат компани
- ❖ **ОНӨААТҮГ** – Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
- ❖ **ТЕЗ** – Төсвийн ерөнхийлөн захирагч
- ❖ **ЕБС** – Ерөнхий боловсролын сургууль
- ❖ **ЗДТГ** – Засаг даргын тамгын газар
- ❖ **НББ** – Нягтлан бодох бүртгэл



2017 ОНЫ ЗОРИЛТ

*“Төрийн аудитын тогтолцооны хууль
эрх зүй, бодлогын шинэтгэл,
ажилтнуудын сахилга, хариуцлагыг
дээшлүүлэх”*

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР

**Нэгдсэн удирдамж төлөвлөгөөний дагуу хийгдсэн гүйцэтгэлийн аудит.
Үүнд:**

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2016 оны хэрэгжилт, үр дүн
- Орон нутгийн 2016 оны төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө болон улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкны эх үүсвэр, векселиэр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг аймаг орон нутагт эрх шилжсэн болон аймгийн ИТХ-аар баталсан төсөл арга хэмжээний хүрээнд 14 төсөл арга хэмжээг хамруулан аудит хийж 2375.6 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 1406.0 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 969.6 сая зөрчилд 9 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж зөвлөмжийн биелэлт хугацаа болоогүй хэрэгжилтийн шатандаа байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар нийт 31 нэр төрлийн 1697.0 сая төгрөгийн үр өгөөжийг шинээр бүртгэн харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэж хэрэгжүүлэх шатандаа байна

2. Орон нутгийн 2016 оны төсвийн гүйцэтгэлд дүгнэлт хийж тайлан, зөвлөмжийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн бөгөөд 5 заалт бүхий зөвлөмжийн хугацаа болоогүй.

Хоёр. НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР

**Нэгдсэн удирдамж төлөвлөгөөний дагуу хийгдсэн нийцлийн аудит.
Үүнд:**

- 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүн
 - Идлэг шонхор шувуу барих, гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хуулийн хэрэгжилт
1. 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүнгийн аудитаар 25 сум байгууллагыг хамруулан аудит хийж 1074.1 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 288.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 210.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 7 байгууллагад албан шаардлага, 10 заалт бүхий зөвлөмжийг гарган холбогдох сумдын төсвийн захирагч нарт хүргүүллээ.

Зөвлөмжийн хэрэгжилтийг шалган түүний мөрөөр хийгдсэн ажлуудын үр дүнг тооцоход 50 хувийн хэрэгжилттэй байна.

Нийцлийн аудитаар нийт 30 нэр төрлийн 1326.0 сая төгрөгийн үр өгөөжийг шинээр бүртгэн харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрөгдөж үр дүнг тооцон ажиллаж байна.

Тайлант оны 4 акт буюу 288.3 сая төгрөгийн төлбөрөөс 165.0 сая төгрөг нь тусгай сангийн дансанд барагдаж, өмнөх оны гүйцэтгэлийн аудитын 16 ширхэг актын 21.0 сая төгрөгийн актаас 2.8 сая төгрөгийн төлбөр барагдсан байна.

2. 2014 онд Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яам Кувейт улсын 4 иргэнтэй байгуулсан гэрээний 3 идлэг шонхор шувуунаас нийт 38400.0 мянган төгрөгийн төлбөр ногдох атал 19200.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж 19200.0 мянган төгрөгийн дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.

Гурав. АЙМГИЙН ИТХ-ЫН ЗАХИАЛГАТ АУДИТ

Аудитаар 115.0 сая төгрөгийн зөрчил илэрч 3.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдон, 25.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг засуулахаар 1 албан шаардлага, 86.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитаар тус байгууллагын орлого бүрдүүлэлт, үр ашиг, зардал хямдруулахтай холбогдон 7 ш бүхий 72.5 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон бүртгэж харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

Дөрөв. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ДҮНГИЙН ТАЛААР

Завхан төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын судалгааны нэгтгэл:

- Төсвийн ерөнхийлөн захирагч
- Төсвийн төвлөрүүлэн захирагч
- Төсвийн шууд захирагч
- Тусгай шилжүүлгийн байгууллага
- Засгийн газрын тусгай сан
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж

Завхан аймгийн босоо бүтэцтэй байгууллагууд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагч
- Төсвийн шууд захирагч
- Засгийн газрын тусгай сан
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дахь заалт, Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалтуудыг

үндэслэн 2016 оны МҮЕАудиторын А/72 дугаар тушаал, 2015 оны МҮЕА-ын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг мөрдөн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулалтыг 2016 оны 1-р сарын 05-наас 4-р сарын 15-ны хооронд өөрийн байгууллагын болон “Гал-авга” аудит ХХК, “Улиастай-Ван” аудит, “Мэдээлэл-Аудит” ХХК-ийн аудитор, шинжээч нарын хүчээр хийж 1393.2 хүн өдөр зарцуулан гүйцэтгэлээ.

2016 оны санхүүгийн тайлан баталгаажуулалт хийгдсэн байгууллагуудын тоо

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Байгууллагын ангилал:								Нийт
		Төсвийн ерөнхийлөн захирагч /тоогоор/	Төсвийн төвлөрүүлэн захирагч /тоогоор/	Төсвийн шууд захирагч /тоогоор/	Хөрөнгө оруулалтын болон бусад зардлын санхүүгийн тайлан /тоогоор/	Тусгай шилжүүлгийн байгууллага	Засгийн газрын тусгай сан /тоогоор/	Төсөл хэрэгжүүлэх нэгж /тоогоор/	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж /тоогоор/	
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9
1	Завхан аймгийн ТЕЗ	1	24	65		118			4	212
2	Завхан аймгийн босоо бүтэцтэй байгууллагууд		2	44			2		5	53
	Нийт	1	26	109		118	2		9	265

2016 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байдал тоогоор

2016 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байдал								
№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Төрийн аудитын газар /тоогоор/	“Гал-авга”Хувийн аудитын компани /тоогоор/	Мэдээлэл аудит” Хувийн аудитын компани /тоогоор/	Улиастай-ван аудит”Хувийн аудитын компани /тоогоор/	Итгэл үзүүлэх/тоогоор/	Түүвэрт хамруулах /тоогоор/	Нийт
A	Б	1	2	3	4	5	6	9
1	Завхан аймгийн ТЕЗ	78	20	16	11	64	23	212
2	Завхан аймгийн босоо бүтэцтэй байгууллагууд	49	1	1		2		53
	Нийт	127	21	17	11	66	23	265

265 санхүүгийн тайланд аудит хийхээс 23 тайланд түүвэр аудит, 66 тайланд итгэл үзүүлж, 157 зөрчилгүй, 7 тайланд зөрчилтэй, 6 тайланд хязгаарлалттай, 1 тайланд татгалзсан дүгнэлт өглөө.

2016 санхүүгийн тайлан баталгаажуулатаар “Зөрчилтэй” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Зөрчилтэй” санал дүгнэлт авсан ТШЗ	“Зөрчилтэй” санал дүгнэлтийн шалтгаан
1	Аймгийн ЗДТГ	- Засгийн газрын 2016 оны 47 тоот тогтоолыг зөрчин 55.7 сая төгрөгөөр урсгал засвар хийж хөрөнгө бэлтгэсэн - 112.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үндэслэлгүйгээр бүртгэлээс хассан - 21.3 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу - 12.9 сая төгрөгөөр төсвийг хэтрүүлэн зарцуулсан - Ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст 6 сарын тэтгэмжид 31.7 сая төгрөгийг олгосон - Төсвийн урсгал санхүүжилтийн болон нэмэлт санхүүжилтийн дансаар 140.6 сая төгрөгийг дамжуулан гаргасан
2	Замын сан	➢ Аймгийн төвийн болон сумдын замын хэвтээ, босоо тэнхлэгийн тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх ТАХ-д 20.0 сая төгрөгийг олгосон бөгөөд ажил хийгдээгүй ➢ 103.4 сая төгрөгийн 4 ТАХ-ний ажил хийгдсэн боловч ажлын гүйцэтгэлийг гаргаж хянаагүй, улсын комисс хүлээн аваагүй
3	Орон нутгийн өмчийн газар	➢ 1.1 сая төгрөгийн бараа материалыг дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн ➢ 3.0 сая төгрөгийн үндэслэлгүй авлага үүсгэсэн ➢ 0.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шийдвэргүйгээр бэлтгэсэн
4	Алдархаан сумын сургууль	➢ 5.8 сая төгрөгийн үдийн цай, байрны хүүхдийн хоолны зардлыг нормативаар зарцуулаагүй, хоолны зарцуулалтын тайланг буруу тайлагнасан ➢ 2.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, ур чадвар хавтгайруулан олгосон ➢ 6.8 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан
5	Асгат сумын сургууль	➢ Хүүхдийн хоолны зардлыг 13,8 сая төгрөгөөр илүү тооцсон
6	Тосонцэнгэл сумын “Тосон-Очирт хайрхан” ОНӨААТҮГ	➢ Бараа материйлын үлдэгдлийг 2.5 сая төгрөгөөр дутуу, үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг 45.8 сая төгрөгөөр алдаатай илэрхийлсэн, өмнөх үеийн ашгийг 4.7 сая төгрөгөөр алдаатай илэрхийлсэн
7	Амь-Ус ХХК ОНӨҮГ	➢ 15.6 сая төгрөгийн хөрөнгө бодитойгоор оршин байгаагүй, 0.3 сая төгрөгийн авлагыг дутуу бүртгэсэн, ➢ 6.7 сая төгрөгийн найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, ➢ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг 72.7 сая төгрөгөөр

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан ТШЗ	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Алдархаан сумын ЗДТГ	➤ Кассаас бэлэн мөнгийг үндсэн баримтгүйгээр зарцуулсан ➤ Сумын ахмадуудад түлээний үнийн хөнгөлөлтийг хавтгайруулан 40 иргэнд 4.0 сая төгрөгийг баримтын бүрдэл дутуу олгосон ➤ Батлагдсан төсвийн зардлыг 14.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн
2	Баянхайрхан сумын ЗДТГ	- 3.3 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу ➤ Цалингийн урьдчилгаа хавтгайруулан олгож 2 ажилтаны цалингийн урьдчилгаа 0.9 сая төгрөгийг суутгалгүйгээр цалингийн зардалд бүртгэсэн ➤ 1.1 сая төгрөгийг кассаас үндсэн баримтгүйгээр зарцуулсан ➤ Жилийн эцсийн санхүүгийн тайланг Аудитын газарт 2 жил дараалан 25-30 хоногоор хоцроон ирүүлсэн ➤ 70.6 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр ирсэн үндсэн хөрөнгийг орлого аваагүй байсныг залруулсан
3	Завханмандал сумын ЗДТГ	➤ 40.0 сая төгрөгийн үнэ бүхий 2 ш дизель станц тооллогын бүртгэлд байгаа боловч бодитоор оршин байхгүй
4	Улиастай 3-р сургууль	➤ Үр дүнгийн тайланд 0.2 сая төгрөгийн зардлыг зүйл ангийн хооронд гүйлгэн зарцуулсан ➤ 2.2 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан ➤ 5.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тодруулгад дутуу илэрхийлсэн
5	Шилүүстэй сумын сум дундын эмнэлэг	➤ Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 3.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, 2.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэн зөв ангилан бүртгээгүй
6	Завхан ХБК	➤ Анхан шатны баримтын бүрдэлгүй 2.4 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн ➤ Хоолны зардлын хэмнэлтийг бусад зардалд урьдчилан шилжүүлж 7.2 сая төгрөгийн авлага үүсгэсэн, 25.2 сая төгрөгийн хүнсний материалыг хэрэгцээнээс илүү нөөцөлсөн ➤ Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тушаагаагүй

“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийн шалтгаан
1	Шилүүстэй сумын сургууль	➤ Үр дүнгийн тайланд 11,2 сая төгрөгийн зардлыг зүйл ангийн хооронд гүйлгэн тайлагнасан ➤ Мөнгөн хөрөнгийн тайланд 8,5 сая төгрөгийн зардлыг зүйл агнийн хооронд гүйлгэн тайлагнасан

Санхүүгийн тайлан баталгаажуулалтаар 23246.3 сая төгрөгийн алдаа илэрч 225.2 сая төгрөгийн алдааг залруулан гаргуулж нэгтгүүлсэн бөгөөд залруулагдаагүй алдааны ихэнх хувийг сумдын сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Төсвийн зарцуулалт, бүртгэлийн үйл ажиллагааны тайланд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан Улсын төсвийн нягтлан

бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэж байх, НББ-ийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах чиглэлээр ЕБС-ийн 7, Цэцэрлэг 49, Эрүүл мэндийн тусгай шилжүүлгийн 6, Нутгийн захиргааны 43, Соёл -1, Политехникийн коллеж-5, Тосон-очир ОНӨҮГ-т 10 зэрэг нийт 68 байгууллагад 2044.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 130 заалт бүхий зөвлөмж өгөгдөж Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид аудитыг дуусгавар болгосон тухай тайланг гардуулсан.

Нийт зөвлөмжийн 105 заалт буюу 80 хувь нь биелэлтийн хариу ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулалтаар төсвийг үрэлгэн зарцуулсан, хөрөнгө оруулалтын ажлуудын санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилдан сэргийлэх тухай хуулийн 22.3, 22.3.1, 22.3.3 -ыг зөрчин 76 м2 орон сууцыг хувийн өмчлөлд шилжүүлсэн. Төрийн албаны тухай хуулин 27.2.4 заалтыг зөрчин өөрийн санаачлагаар ажлаас чөлөөлөгдсөн хүмүүст 6 сартай тэнцэх тэтгэмж олгосон зэрэгтэй холбоотой 32 актаар 259.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 17 актын 114.0 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмыг дагаж мөрдөөгүйгээс тайлан тэнцэлд тоон мэдээллүүдийг алдаатай илэрхийлж, зөрчил дутагдлуудыг давтан гаргасан, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан Улсын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэж байх, УИХ-ын 47 дугаар тогтоолын заалтуудыг мөрдөж ажиллаагүй орон нутгийн төсвийн болон зарим төсвийн 28 байгууллагад 602.3 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж 16 албан шаардлага буюу 344.0 сая төгрөгийн зөрчлийг засч хариу ирүүлсэн, үлдэгдэл нь хугацаа болоогүй байна.

Төсвийг хэмнэлттэй зарцуулах, арвилан хэмнэх, зардал хямдруулахтай холбоотой баталгаажуулалтаар 149 ш бүхий 2983.0 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэж харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж үр дүнг тооцон ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмыг дагаж мөрдөөгүйгээс тайлан тэнцэлд тоон мэдээллүүдийг алдаатай илэрхийлж, зөрчил дутагдлуудыг давтан гаргасан, тайлан тушаах хуулийн хугацааг хэтрүүлсэн хавсралтанд заасан нэр бүхий Нутгийн захиргааны 6, Боловсролын салбар байгууллагуудын 5, ОНӨҮГ-2 нийт 13 бүртгэлийн ажилтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтыг үндэслэн хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн бөгөөд 8 албан тушаалтанд хариуцлага тооцсон албан тоот ирээд байна.

Санхүүгийн тайлан баталгаажуулалтаар 57.4 сая төгрөгийн үйлчилгээний хөлс бичигдсэн бөгөөд 48.8 сая төгрөг нь орон нутгийн орлогын дансанд төвлөрч 26.1 сая төгрөгийг хувийн компаниудад гэрээг дүгнэн олголоо.

265 байгууллага, сангийн санхүүгийн аудитын тайланг заавар журмын дагуу СТАУС программаар бүрэн гүйцэтгэж Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт хугацаанд нь хүргүүллээ.

Өмнөх оны санхүүгийн тайлан баталгаажуулалтаар тавигдсан актын төлбөрийн үлдэгдэл 7актын 22.0 сая төгрөгөөс 2.5 сая төгрөг нь орон нутгийн төсвийн дансанд барагдсан байна.

Тав. ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦ УДИРДЛАГА НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөлгөөнд дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер оролцон ажилтнуудад сургалт, зөвлөлгөөний талаар мэдээлэл хийлээ.

Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг Үндэсний аудитын газарт хүргүүлэн үр дүнгийн гэрээг Орон нутаг хариуцсан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчтой байгууллаа.

Төрийн жинхэнэ албан хаагчидтай 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулан байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий аудитортой байгуулсан бүтээгдэхүүний төлөвлөгөөг үндэслэн 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний 8 бүлэг 41 заалт бүхий асуудлыг төлөвлөн дарга, тэргүүлэх аудиторoor батлуулан ажиллаж ирлээ.

Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг тооцож үзэхэд 30 заалт бүхий асуудал хэрэгжсэн бөгөөд 73.2 хувьтай зарим ажлууд хэрэгжилтийн шатандаа байна.

Тайлант онд 6078.0 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэж 4523.9 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн байна.

Дээрх зорилтууд дэвшүүлсэн асуудлуудыг биелүүлэхийн тулд батлагдсан 11 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулан нийт 9 хүн 1771 хүн өдөр ажиллаж 265 байгууллагын санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийж, нэгдсэн удирдамж төлөвлөгөөгөөр гүйцэтгэлийн аудит 2, нийцлийн аудит 2, аймгийн ИТХ-ын захиалгат аудит 1 нийт 5 аудитыг хийсэн.

2017 оныг “Төрийн аудитын тогтолцооны хууль эрх зүй, бодлогын шинэтгэл, ажилтнуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил болгосонтой холбогдуулан ажилтнуудад МУЕА-ын төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн дээр тавьсан илтгэлийг сонсгож “Захирааны Ерөнхий хууль”, “Монгол Улсын төрийн нууцын тухай хууль”, “Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийн талаар дотоод сургалтуудыг хийв

Албан хаагчдын ажлын цагийн ашиглалтыг сайжруулан аймгийн Засаг даргын тамгын газрын цахим бүртгэлд ажилтнуудын хурууны хээг оруулан

бүртгэлийг хянадаг болсон бөгөөд санхүүгийн тайлан баталгаажуулалтын хугацаанд уртасгасан цагаар амралтын өдрүүдэд ажиллуулан хүлээх үүрэг, сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн аудитын газраас зохион байгуулсан ТЕЗ тайлан болон Төсвийн гүйцэтгэлийн аудиттай холбоотой онлайн хурал, Гүйцэтгэлийн аудитын газраас зохион байгуулсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, векселиэр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаар, Нийцлийн аудитын газраас зохион байгуулсан ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт үр дүнгийн талаар болон Стратеги удирдлагын газар болон Тамгын газраас зохион байгуулсан онлайн хурлуудад хамт олноороо байнга оролцож ирсэн.

Сонсох үйл ажиллагааны болон байгууллагын гэрчилгээ тамга, тэмдэг өөрчлөхтэй холбоотой онлайн хуралуудад бүрэн оролцож, сонсох ажиллагааны мэдэгдэл, тэмдэглэлийг ажилтнуудаар баталгаажуулан цаасаар болон цахимаар явуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн ухуулах байр, менежер, шадар туслагч, ухуулагчдын жагсаалтыг гаргуулах албан тоотыг МАН, АН, МАХН-д хүргүүлэн тоон мэдээ, нэрсийн жагсаалтыг гаргуулан хяналт хийж Нийцлийн аудитын газарт 2017.06.22-нд хугацаанд нь хүргүүллээ.

ҮАГ-аас ирүүлсэн аудитын тайлан хэлэлцэх журам, ажлын байрны тодорхойлолт, төрийн аудитын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам, төрийн аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдвийг сонгох, төлөвлөх, бүртгэх журам, төрийн аудитын байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээ, дотоод жишгийг тогтоох тухай төсөл болон бусад журам, төсөлд санал хүргүүлсэн.

Мөн ТЕЗ-ийн тайлан болон Төсвийн гүйцэтгэлийн аудиттай холбоотой судалгаа, албан гадаад паспортын талаарх судалгаа, ажилчидтай холбоотой судалгаа, ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын судалгаа, ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдэг байгууллагуудын болон санхүүгийн тайлан баталгаажуулалт хийгдсэн бүх байгууллагуудын судалгаа, 2016 онд гэрээгээр ажилласан 3 хувийн аудитын комданиудын санхүүгийн тайлан баталгаажуулалт хийгдсэн байгууллагуудын жагсаалт, бичигдсэн үйлчилгээий хөлсний жагсаалтыг, 2017 онд өөрийн санаачлагаар хийгдэх гүйцэтгэлийн аудит 2, нийцлийн аудитаар хийх 1 байгууллагын хамрах хүрээ, аудит хийгдэх хугацаа, санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөжийн тооцоо, 2015, 2016 онуудад өөрийн санаачлагаар хийгдсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын хамарсан хүрээ, зөрчил төлбөр, үр өгөөж, үр дүнгийн талаарх судалгааг, Аймгийн ИТХ-ын болон өөрийн санаачлагаар 2012-2016 онд хийж гүйцэтгэсэн аудитын төрөл, хамрагдсан хүрээ, илрүүлсэн зөрчил, тогтоогдсон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн тоо, 2017 онд хийх Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын сэдвийн судалгаа, төрийн аудитын газруудын дарга, тэргүүлэх аудиторуд болон менежерүүд мэргэшил, ур чадвар, дээшлүүлэх сургалтын

судалгаа, 2017 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах 260 байгууллагын судалгаа, ОНХС-ийн аудитын судалгаа, албан хаагчдын тухайн ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэх талаарх судалгааг тус тус гарган цаасаар болон файлаар холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлээ.


“Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, векселиэр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаар, ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын аудитуудын дэд хөтөлбөр батлуулан төсөл арга хэмжээний ажлуудын чанар, бодит гүйцэтгэлийг аймгийн 24 суманд очиж газар дээр нь үзэн үнэлгээ өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн тайлан, дүгнэлтийг Засаг даргад хүргүүлэн холбогдох удирдлагуудтай хэлэлцүүлэг хийлээ.



Байгууллагын санхүү болон дотоод ажил, санхүүгийн тайлан баталгаажуулалтын 265 байгууллагын санхүүгийн тайлан, аудиттай холбоотой материалууд, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын шалгалтын материалуудыг төрөлжүүлэн үдэж эмхлэн архивын стандартын дагуу нэгдсэн дугаарт оруулан цэгцлэв.

Аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07 тоот, 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 05 тоот албан даалгаваруудын дагуу Нутгийн захиргааны ордон дэргэдэх орчмыг зүлэгжүүлэх, ногоон байгууламж бий болгох ажилд хамт олноороо оролцон 215 м.кв газрыг зүлэгжүүлэх ажлыг хариуцан авч усалгаа арчилгааг хийж үр дүнг тооцож байна.



Аймгийн ИТХ-д Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн тайлан, дүгнэлтийг хүргүүлж санхүүгийн аудитаар сөрөг болон хязгаарлалттай санал, дүгнэлт авсан, удаа дараа зөрчил гаргаж байгаа албан тушаалнуудад сахилгын шийтгэл ногдуулах саналыг дээд шатны томилох бүхий албан тушаалтнуудад хүргүүллээ.

Тус байгууллага нь долоо хоногийн нэг дэх өдөр бүр шуурхай хурал хийж аудитор, шинжээч нарын өмнөх 7 хоногт хийсэн ажлын тайлан, цаашид хийх ажлыг сонсон хурлын тэмдэглэл хөтлөн биелэлтийг тооцон ажиллаж, өмнөх оны албан шаардлага, актын төлбөрийн үлдэгдлийг хянан барагдуулах үүрэг чиглэл өгөх, зарим хугацаа хэтэрсэн болон хүлээн зөвшөөрөгдөөгүй актуудыг Шүүхийн байгууллагад шилжүүлэх, биелэлтийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу харицлага ногдуулж ажилласан байна.

Аудиторуудыг багаар ажиллах чадвар, багийн ажлын үр дүнд анхааран ажиллаж аудитын үе шатны болон чанарын хяналтуудыг хийж үр дүнг тооцох, өгсөн үүрэг даалгаврын тэмдэглэлийг хөтөлж хэвшлээ.

Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллан ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг аудит хийх тухай бүр гаргаж хэвшсэн.

Төрийн аудитын тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлд заасны дагуу 2017 онд хийсэн санхүүгийн болон гүйцэтгэл нийцлийн аудитын тайланг УАГ-т хүргүүлж нэгдсэн портал сайтанд байрлуулан олон нийтэд мэдээллээ.

Тайлант хугацааны 278 тайланг хэвлэмэлээр болон хувилж тараасан, ирсэн болон явсан бичгүүдийг бүртгэн хариуг тухай бүр хүргүүлсэн бөгөөд байгууллага болон иргэдээс ирсэн 6 өргөдлийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэлээ.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, 2016 оны ажилтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан Үндэсний аудитын газар болон Авлигатай тэмцэх газарт хүргүүллээ.

Зургаа. САНХҮҮГИЙН ТАЛААР

Байгууллага 2017 оны эхний хагас жилд 104.2 сая төгрөгийн орлого, санхүүжилттэй үйл ажиллагаа явуулан төсвийг зохих хууль журам, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж ирлээ.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах, Төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах, үүднээс өөрийн санхүүгийн үйл ажиллагааны зарцуулалтыг www.audit.mn сайтад тогтмол мэдээлсэн.

Төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангуулан ажилтнуудад төсвийн талаар мэдээлэл хийж арвилан хэмнэлттэй байх талаар анхаарч санхүүгийн тайлан

мэдээг зохих цаг хугацаанд нь гаргаж хэрэглэгч болон удирдлагыг санхүүгийн мэдээллээр бүрэн хангаж ажиллалаа.

Батлагдсан санхүүжилтийн хэмжээнд хийгдсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар аймгийн 24 суманд ажилласан ажилтнуудын албан томилолт, шатахууныг цаг хугацаанд нь бүрэн гаргаж өгч аудитыг хурдан шуурхай гүйцэтгүүллээ.

Сумдад ажиллах үеэр байгууллагын үйлчилгээний автомашины зарим эд ангиуд эвдрэн ажил үйлчилгээ гүйцэтгэх боломжгүй болж хүндрэл учирч байсан бөгөөд ҮАГ-ын удирдлагуудад бодит байдлыг танилцуулсан бөгөөд өгсөн үүрэг чиглэлийн дагуу аймгийн удирдлагуудад хандан 15.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авахаар хүсэлт, тооцоог хүргүүлэн шийдвэрлүүлж засвар үйлчилгээг бүрэн хийж байгууллагын үйлчилгээний автомашин LEXUS-470 ЗАН-3958 ажил үйлчилгээнд бэлэн болж ашиглаж байна.

2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хугацаанд нь гаргаж явуулан байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хийж тооцоо бодож дүн дүгнэлт, жагсаалтыг гаргаж удирдлагын зөвлөлөөр оруулан хэлэлцүүлэн 2017.06.15-нд хугацаанд нь Ажлын албанд хүргүүллээ.

ЗАВХАН ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР